



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2017 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**Монгол Улсын Засгийн газарт
чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ НЬ:

Нэг.Улсын Их Хурлын 2012 оны “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоол, Өргөдлийн байнгын хорооны 2016 оны 03 дугаар тогтоолуудын хэрэгжилтийн талаар холбогдох төрийн байгууллагуудын мэдээлэл сонсож, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээд арьс ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх тухай Улсын Их Хурлын 74 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх “Харгиа” цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах, бохирдлыг бууруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар дараах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т чиглэл болгосугай:

1/Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолын 2.5-д заасан Арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл ажиллагааны саналаа 2017 оны 3 дугаар улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Эмээлтийн үйлдвэрлэл, технологийн паркийн үйлдвэрлэлийн бүс, суурьшлын бүс, хамгаалалтын бүс, заагийг тогтоох;

3/Эмээлтийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх;

4/Арьс, ширний үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх хүртэл “Харгиа” цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлд арга хэмжээ авах;


5/Арьс, шир, ноос, ноолуурын үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламж барих, газрын байршил тогтоох, зураг төслийг хийхдээ “Эрүүл ахуйн тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг хангахад анхаарах;

6/Хууль, тогтоомж, стандарт зөрчин үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцох.

Хоёр.Тогтоолын биелэлтийг 2017 оны намрын чуулганы хугацаанд багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн

газар /Ж.Эрдэнэбат/, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /Д.Оюунхорол/, Барилга, хот байгуулалтын яам /Г.Мөнхбаяр/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /П.Сэргэлэн/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н.Цагаанхүү/, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдод тус тус даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.САРАНГЭРЭЛ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2017 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Нэг.Арьс, ширний үйлдвэрүүд стандартаас 2-5 дахин их бохир усыг Туул голд урсгаж байгаа талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийн дагуу Байнгын хорооноос Улсын Их Хурлын 2012 оны “Малчид үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоолын 5 дугаар заалтын биелэлтийг хангуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, санал дүгнэлт боловсруулж Байнгын хорооны хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Билэгт Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Д.Сарангэрэл Улсын Их Хурлын гишүүн
А.Сүхбат Улсын Их Хурлын гишүүн
Н.Цэрэнбат Улсын Их Хурлын гишүүн
Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Х.Энэбиш Өргөдлийн байнгын хорооны ахлах зөвлөх

Хоёр.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, судалгаа хийх ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Л.Баяртулга Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Ш.Мягмар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга

Л.Эрдэнэбулган Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нөөцийн газрын дарга

О.Лхагвацэдэн	Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Б.Батхүү	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Д.Цэрэндаш	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчны хяналтын хэлтсийн дарга
Д.Баярболд	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга
Д.Бат-Өлзий	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын хэлтсийн дарга
Я.Болдбаатар	Туул голын сав газрын захиргааны дарга
Э.Баттулга	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын дарга
Ц.Төрхүү	Нийслэлийн Ус сувгийн удирдах газрын дарга
Б.Бат-Эрдэнэ	Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газрын дарга
Х.Эрдэнэбилэг	Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк, орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дарга
Г.Батсайхан	Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч
Б.Болорчимэг	Өргөдлийн байнгын хорооны зөвлөх
Ц.Энх-Амгалан	Өргөдлийн байнгын хорооны референт

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.САРАНГЭРЭЛ